



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 9/50

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.5, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2023 оны 15 дугаар хуралдааны тэмдэглэл, Газрын дүрмийн 4.1.4, 4.1.8, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэхэд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөг дүүрэг бүрт хариуцан хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг батлагдсан удирдамж, хуваарийн дагуу холбогдох нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулж, явц үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгүүдэд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э. Даваахатан)-т даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2023 оны А/20 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

